

Төсөл

КЛИРИНГИЙН СИСТЕМИЙН ОПЕРАТОР БОЛОН ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасныг үндэслэж клирингийн системийн оператор, төлбөр тооцооны төлөөлөгчид тавигдах шаардлага, үүрэг хариуцлага, клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, татгалзах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Клирингийн системийн оператор, төлбөр тооцооны төлөөлөгч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 1.3 Үндэсний цахим гүйлгээний төвийн үйл ажиллагаанд энэ журам хамаарахгүй.

ХОЁР.НЭР ТОМЬЁО

- 2.1 “Клиринг” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.28-д заасныг
- 2.2 “Клирингийн систем” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.4-т заасныг;
- 2.3 “Клирингийн системийн оператор” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.4-т заасан системийг ажиллуулах, 5.1.12-т заасан этгээдийг;
- 2.4 “Төлбөр тооцооны төлөөлөгч” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.13-т заасныг;
- 2.5 “Клирингийн системийн оролцогч (цаашид оролцогч гэх)” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.7-д заасан, клирингийн системд холбогдож төлбөр илгээх, хүлээн авах этгээдийг;
- 2.6 “Шууд оролцогч” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.8-д заасан этгээдийг;
- 2.7 “Шууд бус оролцогч” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-д заасан этгээдийг.
- 2.8 “Төлбөр тооцоо” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.26-д заасныг;

2.9 “Үр дүнгийн тооцоолол” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.29-т заасныг;

2.10 “Үр дүнгийн тооцооллын хаалтын дүн” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.30-д заасныг;

ГУРАВ.КЛИРИНГИЙН СИСТЕМИЙН ОПЕРАТОРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Клирингийн системээр дамжих гүйлгээ тус бүрийн мөнгөн дүнгийн дээд хэмжээ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан бага дүнтэй төлбөрийн дүнгийн дээд хязгаартай тэнцүү байна.

3.2 Энэ журмын 3.1-т заасан мөнгөн дүнгийн дээд хэмжээ төлбөрийн картын гүйлгээнд хамаарахгүй.

3.3 Клирингийн системийн оператор нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана:

3.3.1 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу системийн дүрэм тогтоож, Монголбанкинд хянуулж, бүртгүүлэх;

3.3.2 Дүрмийг клирингийн системийн операторын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байх;

3.3.3 Өөрийн оролцогч болон Монголбанктай үйл ажиллагааны туршилт хийж, Монголбанкнаас дүгнэлт гаргуулах;

3.3.4 Үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг “Банксүлжээ” системд дамжуулах;

3.3.5 Санхүүгийн мэдээний олон улсын ISO20022 стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.3.6 Оролцогчтой мэдээлэл солилцох, санал гомдол, хүсэлтийг хүлээн авах 24 цагийн оператор болон цахим хаягтай байх;

3.3.7 Алдаатай эсвэл нэр, данс зөрсөн гүйлгээ дамжихгүй байх нөхцлийг хангаж, үүссэн маргааныг шийдвэрлэх тогтолцоотой байх;

3.3.8 Монголбанк эсвэл төлбөр тооцооны төлөөлөгчийн шаардлагаар оролцогчийн үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тухайн оролцогчийн төлбөр тооцооны данс дахь мөнгөн хөрөнгийн боломжит дүнгээс илүүгүй байхаар хязгаарлах техник, технологийн чадамжтай байх;

3.3.9 Хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах мэдээллийн технологийн систем, техник, тоног төхөөрөмж, байршиж буй барилга байгууламж бүхий мэдээллийн технологийн үндсэн төвтэй байх;

3.3.10 Үндсэн төвд онцгой байдал үүсэх үед түүний үйл ажиллагааг шилжүүлэн тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх зорилгоор байгуулсан мэдээллийн

технологийн систем, техник, тоног төхөөрөмж, байршиж буй барилга байгууламж бүхий мэдээллийн технологийн нөөц төвтэй байх;

- 3.3.11 Нөөц төвийн системийн аюулгүй байдлын үзүүлэлт нь үндсэн төвийн системийн үзүүлэлтээс доошгүй байх;
 - 3.3.12 Үндсэн болон нөөц төвийн бүтэц, үйл ажиллагаа нь Монголбанкнаас баталсан “Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ын шаардлагад нийцсэн байх;
 - 3.3.13 Мэдээллийн технологийн систем, түүний техник, тоног төхөөрөмж, мэдээллийн бааз нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байрших.
- 3.4 Энэ журмын 3.3.1-т заасан дүрэмд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 23.1-т зааснаас гадна дараах зүйлсийг тусгасан байна:
- 3.4.1 Оролцогчид тавигдах шаардлага;
 - 3.4.2 Клирингийн системийн оператор болон оролцогчийн эрх, үүрэг;
 - 3.4.3 Клирингийн системд холбогдох тавигдах техникийн шаардлага, цахим мэдээний стандарт;
 - 3.4.4 Үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн дэлгэрэнгүй тайлбар;
 - 3.4.5 Үйлчилгээний хөлс, шимтгэлийн хэмжээ;
 - 3.4.6 Гүйлгээ дамжуулах, баталгаажуулах, үр дүнгийн тооцоолол хийх, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг Монголбанкинд дамжуулах хуваарь, зарчим;
 - 3.4.7 Маргаан шийдвэрлэх зарчим;
 - 3.4.8 Дүрэмд орсон өөрчлөлтийг оролцогчдод мэдэгдэх хугацаа.
- 3.5 Техник, програм хангамжийн алдаа, хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл, гал түймэр, гэнэтийн осол, байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн (газар хөдлөлт, хүчтэй салхи, үер, аянга зэрэг) болон бусад шалтгаанаар мэдээллийн технологийн системийн хэвийн үйл ажиллагаа алдагдахыг онцгой байдал үүссэнд тооцно.

ДӨРӨВ. КЛИРИНГИЙН СИСТЕМИЙН ОПЕРАТОРЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 4.1 Клирингийн системийн оператор нь дараах үүргийг хүлээнэ:
- 4.1.1 Системийн оролцогч болон Монголбанктай хамтран ажиллах гэрээ байгуулна.
 - 4.1.2 Өөрийн системийн дүрэмд заасны дагуу гүйлгээг дамжуулж, тохируулж, баталгаажуулж, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тодорхойлно.

- 4.1.3 Үр дүнгийн тооцооллыг ажлын өдрүүдэд 24 цагт 1 (нэг)-ээс доошгүй удаа гүйцэтгэнэ.
- 4.1.4 Үр дүнгийн тооцооллын хаалтын дүнгийн мэдээллийг дараагийн ажлын өдрийн 16:30 цагаас өмнө Монголбанкинд дамжуулна.
- 4.1.5 Оролцогчийг маргаан шийдвэрлэх боломжоор хангаж, хяналт тавина.
- 4.1.6 Клирингийн системээр дамжих гүйлгээний болон мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдлыг хангана.
- 4.1.7 Оролцогч нарт ижил нөхцөлөөр техникийн шаардлага, үйлчилгээний нөхцөл, хөлс, шимтгэл тогтооно.
- 4.1.8 Монголбанкнаас баталсан “Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, мөн өөрийн оролцогч нараар дагаж мөрдүүлнэ.
- 4.1.9 Хулгайн ба залилангийн гүйлгээний талаарх мэдээллийн санг үүсгэж, хууль хэрэгжүүлэгч байгууллагын шаардлагаар холбогдох мэдээллийг өгнө.
- 4.1.10 Гүйлгээ, харилцагч болон тэдгээртэй холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасан, шүүхийн шийдвэр, прокурорын зөвшөөрөл гарснаас бусад тохиолдолд бусдад задруулахыг хориглоно.
- 4.1.11 Шаардлагатай тохиолдолд өөрийн оролцогчдыг системийн хэмжээний тоон мэдээлэл болон тухайн оролцогчийн гүйлгээний талаарх мэдээллээр хангана.
- 4.1.12 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 6 (зургаан) сарын дотор өөрийн үйл ажиллагааг эхэлнэ.
- 4.2 Клирингийн системийн оператор нь системийн дүрмийг ил тод, нээлттэй байлгах зорилгоор өөрийн цахим хаягт байршуулна.

ТАВ.ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 5.1 Төлбөр тооцооны төлөөлөгч нь Монголбанк болон шууд бус оролцогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн шууд бус оролцогчийн төлбөр тооцоог өөрийн Монголбанк дээрх дансаар дамжуулан гүйцэтгэнэ.
- 5.2 Төлбөр тооцооны төлөөлөгч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангана:
- 5.2.1 Өөрийн оролцогч болон Монголбанктай үйл ажиллагааны туршилт хийж, Монголбанкнаас дүгнэлт гаргуулах;
- 5.2.2 Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

5.2.3 Сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай гүйцэтгэсэн байх;

5.2.4 Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор Монголбанк дахь өөрийн харилцах дансны мөнгөн хөрөнгөөс энэ журмын 3.3.8-д заасан дүнгээр барьцаалахыг зөвшөөрөх;

5.2.5 Шууд бус оролцогчид ижил нөхцөлөөр шаардлага тавих, үйлчилгээ авах болон үйл ажиллагаа эрхлэх эрх тэгш боломжоор хангах;

5.2.6 Шууд бус оролцогч нарт ногдуулах хөлс, шимтгэл, нөхцөл нь ижил байх;

5.3 Энэ журмын 5.2.4-т заасан хөрөнгийг барьцаалах үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

ЗУРГАА.ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

6.1 Төлбөр тооцооны төлөөлөгч нь дараах үүргийг хүлээнэ:

6.1.1 Шууд бус оролцогчоос төлбөр тооцооны зорилгоор байршуулсан мөнгөн хөрөнгийг зөвхөн үр дүнгийн төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор ашиглах;

6.1.2 Оролцогчтой холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасан, шүүхийн шийдвэр, прокурорын зөвшөөрөл гарснаас бусад тохиолдолд бусдад задруулахыг хориглоно.

6.1.3 Мэдээллийн технологийн найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж, Монголбанкнаас баталсан “Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ыг дагаж мөрдөнө.

6.1.4 Төлбөр тооцооны төлөөлөгч нь шууд бус оролцогчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг хариуцна.

ДОЛОО.ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

7.1 Клирингийн системийн операторын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг байна.

7.2 Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий этгээдэд энэ журмын 7.1 дэх заалт хамаарахгүй.

7.3 Хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээс бүрдүүлээгүй байна.

НАЙМ.ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

8.1 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын 6 дугаар хавсралтад заасан баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ.

- 8.2 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын 8.1-т заасан баримт бичгийг ирүүлэхдээ Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14.1, энэ журмын 3.3-т заасан шаардлагыг хэрхэн хангасан тухай тайлбарыг хавсаргасан байна.
- 8.3 Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын 5 дугаар хавсралтад заасан баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ.
- 8.4 Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын 8.3-т заасан баримт бичгийг ирүүлэхдээ Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1, энэ журмын 5.2-т заасан шаардлагыг хэрхэн хангасан тухай тайлбарыг хавсаргасан байна.
- 8.5 Монголбанк энэ журмын 8.1 болон 8.3-т заасан баримт бичгийг хянаж, бүрдүүлбэр дутуу, нэмэлт материал шаардлагатай тохиолдолд 30 (гуч) хоногийн дотор хүсэлт гаргагчид албан бичгээр эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 8.6 Хүсэлт гаргагч нь Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу зөвшөөрлийн материал хүлээж авах хураамжыг төлөх бөгөөд зөвшөөрлийн баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах, нэмэлт материал ирүүлэх тохиолдолд зөвшөөрлийн материал хүлээж авах хураамжыг дахин төлөхгүй.
- 8.7 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгох асуудлыг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.8 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгох шийдвэр гарсан тохиолдолд хүсэлт гаргагч нь Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан холбогдох зөвшөөрлийн хураамжийг төлнө.
- 8.9 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд зааж, энэ журамд тодорхойлсон шаардлагыг хангасан, зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл байхгүй бол хүсэлт гаргагчид зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар олгоно.
- 8.10 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан хугацаагаар олгоно.
- 8.11 Клирингийн системийн оператор, төлбөр тооцооны төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх бол энэ журмын 8.10-т заасан зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос 180 хоногийн өмнө зөвшөөрөл сунгах хүсэлт гаргана.
- 8.12 Зөвшөөрөл сунгах хүсэлтийг энэ журмын 8.1-8.9-т заасны дагуу шийдвэрлэж, зөвшөөрлийг хугацаагүй олгоно.
- 8.13 Монголбанк дараах үндэслэлээр клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзана. Үүнд:

- 8.13.1 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15.3-т заасан хугацаа хэтэрсэн;
- 8.13.2 Үндэсний төлбөрийн систем, эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж Монголбанк үзсэн.
- 8.14 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан тухай Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15.2-г үндэслэн хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 8.15 Зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан хариу авсан этгээд дахин хүсэлт гаргах тохиолдолд энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн хүсэлт гаргана.
- 8.16 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.1-т заасан болон дараах үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:
- 8.16.1 Энэ журамд заасан шаардлага, үүргийг удаа дараа биелүүлээгүй нь тогтоогдсон;
- 8.16.2 Монголбанкны хяналт шалгалтаар үндэсний төлбөрийн систем болон нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдсон;
- 8.16.3 Энэ журмыг мөрдөж ажиллах боломжгүй болсон.
- 8.17 Төлбөрийн системийн хяналт, шалгалтаар энэ журмын 8.16-д заасан зөрчлийг арилгасан нь тогтоогдвол шалгалтын дүгнэлтийг үндэслэн Монголбанкны шийдвэрээр холбогдох зөвшөөрлийг сэргээнэ.
- 8.18 Клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг сэргээхдээ түдгэлзүүлсэн хугацааг нөхөн олгохгүй.
- 8.19 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.2-т заасан үндэслэлээр клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 8.20 Хүчингүй болсон зөвшөөрлийг дахин олгох тухай хүсэлтийг Монголбанк тухайн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын хугацаанд хүлээн авахгүй бөгөөд хүсэлт гаргагч нь тогтоосон хугацааны дараа энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн хүсэлт гаргана.
- 8.21 Энэ журмын 8.16 болон 8.19-д заасан үндэслэлээр клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авахтай холбогдон гарсан зардлыг тухайн хуулийн этгээд хариуцна.

ЕС.МЭДЭЭЛЭЛ ХАДГАЛАХ

- 9.1 Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгч нь гүйлгээний мэдээг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт заасны дагуу хадгална.
- 9.2 Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгч нь системийн логийг 2 (хоёр)-оос доошгүй жил хадгална.

АРАВ.ТАЙЛАН МЭДЭЭ

- 10.1 Клирингийн системийн оператор нь банк, банк бус санхүүгийн байгууллагаас бусад хуулийн этгээд байх тохиолдолд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан өмнөх жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайланг Монголбанкинд хүргүүлнэ.
- 10.2 Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагааны тайланг сар тутам үнэн зөв гаргаж, дараа сарын ажлын эхний 10 (арван) өдрийн дотор Монголбанкинд энэ журмын 1 болон 2 дугаар хавсралтад заасны дагуу цахим хэлбэрээр ирүүлнэ.
- 10.3 Клирингийн системийн оператор нь өөрийн болон оролцогчийн үйл ажиллагааны доголдол, тасалдал, түүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг сар тутам үнэн зөв гаргаж, дараа сарын ажлын эхний 10 (арван) өдрийн дотор Монголбанкинд цахим хэлбэрээр ирүүлнэ. (Хавсралт 3)
- 10.4 Төлбөр тооцооны төлөөлөгч нь өөрийн оролцогчид төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор зээл олгодог бол олгосон зээлийн тайланг сар тутам үнэн зөв гарган дараа сарын ажлын эхний 10 (арван) өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ. (Хавсралт 4)
- 10.5 Клирингийн системийн оператор нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа саатал, зөрчил илэрсэн тохиолдол бүрийг бүртгэж, Монголбанкинд тухай бүр мэдэгдэнэ.
- 10.6 Клирингийн системийн оператор эсхүл төлбөр тооцооны төлөөлөгч нь гүйлгээ, төлбөр тооцоотой холбоотой үүссэн маргааныг шүүх, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлсэн тохиолдолд холбогдох дүгнэлтийг Монголбанкинд тухай бүр ирүүлнэ.
- 10.7 Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад тайлан мэдээг тухай бүр Монголбанкинд ирүүлнэ.

КЛИРИНГИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЫ
САРЫН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

1. Клирингийн системээр дамжиж өнгөрсөн гүйлгээ

Төрөл (төлбөрийн суваг, хэрэгслээр-карт, хөдөлгөөнт банк г.м)	Гүйлгээний үзүүлэлт	Гүйлгээний тоо	Дүн
	Амжилттай гүйлгээ		
	Амжилтгүй гүйлгээ		
Нийт			

2. Клирингийн системээр дамжиж өнгөрсөн амжилтгүй гүйлгээ

Шалтгаан	Тоо	Дүн
Нийт		

3. Клирингийн системээр дамжсан гүйлгээ оролцогч тус бүрээр

Оролцогчийн нэр	Илгээсэн гүйлгээний дүн	Илгээсэн гүйлгээний тоо ширхэг	Хүлээн авсан гүйлгээний дүн	Хүлээн авсан гүйлгээний тоо ширхэг
Нийт				

ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
... ОНЫ ... САРЫН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

Оролцогчийн нэр	Төлбөр тооцооны нийт дүн	Хамгийн их дүнтэй төлбөр тооцоо*	Төлбөр тооцооны дундаж дүн
Нийт			

* Тухайн сард хийгдсэн хамгийн их дүнтэй нэг удаагийн төлбөр тооцоо

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДОГОЛДОЛ, ТАСАЛДАЛ, ТҮҮНД
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ОНЫ САРЫН
ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

Огноо	Доголдол, тасалдлын шалтгаан	Үйл ажиллагаа тасалдсан хугацаа	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ/Тайлбар

ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫГ ХАНГУУЛАХ
ЗОРИЛГООР ОЛГОГДСОН ЗЭЭЛИЙН ОНЫ САРЫН
ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

Зээл олгосон огноо	Зээлдэгчийн нэр	Зээлийн хэмжээ	Барьцаа хөрөнгийн нэр, төрөл	Зээл буцаан төлөгдсөн огноо

**ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХҮСЭЛТ
ГАРГАГЧИЙН БАРИМТ БИЧГИЙН БҮРДҮҮЛБЭР**

№	Ирүүлэх баримт бичгийн жагсаалт	Баримт бичгийг бүрдүүлсэн эсэх		
		Тийм	Үгүй	Тайлбар
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл			
2	Эрхлэх үйл ажиллагааны талаарх танилцуулга, холбогдох баримт бичиг			
3	Оролцогчтой байгуулах гэрээний загвар			
4	Төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааг зохистой, найдвартай, тогтвортой үзүүлэхэд шаардлагатай систем, нөөцтэй, тэдгээрийг ашиглах чадвартайг нотолсон баримт бичиг,			
5	Төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эхний 5 (таван) жилийн бизнес төлөвлөгөө, журам, дүрэм			
6	Мөнгө угаах болон, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлснийг нотлох баримт бичиг			
7	Зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн аргачлал бүхий удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт зэргийг зохицуулсан баримт бичиг			
8	Оролцогчийн мөнгөн хөрөнгийг хамгаалахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай баримт бичиг			
9	Байгууллагын бүтэц, зохион байгуулалттай холбогдсон баримт бичиг			
10	Удирдлагын болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагаа хариуцсан нэгжийн			

	удирдах ажилтны мэдээлэл			
11	Хүсэлт гаргагчтай холбогдох этгээдийн мэдээлэл			
12	Хүний нөөцийн талаарх мэдээлэл			
13	Гүйлгээний мэдээллийг боловсруулах, хадгалах явцад мэдээллийг задруулах, буруугаар ашиглах, устгах, өөрчлөх, хулгайлах, мэдээлэл алдагдахаас хамгаалсан арга хэмжээний талаарх баримт бичиг			
14	Холбоо барих мэдээлэл			
15	Зөвшөөрлийн материал хүлээж авах хураамж төлсөн баримт			

Жич: Хүснэгт дэх “Тайлбар” хэсэгт ирүүлэхийг шаардсан баримт бичгийн бүрдүүлбэрийг хэрхэн хангаж байгаа талаар болон холбогдох материал, дүрэм, журам, гэрээний заалтыг тодорхой заана уу.

**КЛИРИНГИЙН СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

№	Ирүүлэх баримт бичгийн жагсаалт	Баримт бичгийг ирүүлсэн эсэх		
		Тийм	Үгүй	Тайлбар
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл			
2	Ажиллуулах системийн дэлгэрэнгүй танилцуулга,			
3	Системийн дүрэм			
4	Оролцогчтой байгуулах гэрээний загвар			
5	Систем ажиллуулахад ашиглах хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг (Зөвхөн банкнаас бусад хуулийн этгээдэд хамаарна)			
6	Өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангаж буйг илтгэх баримт бичиг (Зөвхөн банкнаас бусад хуулийн этгээдэд хамаарна)			
7	Систем ажиллуулах эхний 5 (таван) жилийн бизнес төлөвлөгөө			
8	Зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн аргачлал бүхий удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт зэргийг зохицуулсан баримт бичиг			
9	Байгууллагын бүтэц, зохион байгуулалттай холбогдсон баримт бичиг (аутсорсингийн үйлчилгээ авах бол тухайн шийдвэр, үндэсний болон олон улсын төлбөрийн системд оролцохтой холбогдсон баримт бичиг)			
10	Мэдээллийн технологийн систем, техникийн тодорхойлолт, мэдээллийн технологийн бүтэц, ажиллагааг тусгасан баримт бичиг			
11	Үндсэн систем, үндсэн төвийн			

	үйл ажиллагаа доголдсон нөхцөлд авч хэрэгжүүлэх онцгой байдлын болон тасралтгүй, найдвартай ажиллагааны төлөвлөгөө			
12	Гүйлгээний мэдээллийг боловсруулах, хадгалах явцад мэдээллийг задруулах, буруугаар ашиглах, устгах, өөрчлөх, хулгайлах, мэдээлэл алдагдахаас хамгаалсан арга хэмжээний талаарх баримт бичиг			
13	Оролцогч төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүй, төлбөрийн чадваргүй болсны улмаас системд учруулах эрсдэлийг хязгаарлах, удирдах арга хэмжээ, эрсдэлийн дүн шинжилгээ			
14	Удирдлагын болон системийг хариуцах нэгжийн удирдах ажилтны мэдээлэл			
15	Хүсэлт гаргагчтай холбогдох этгээдийн мэдээлэл			
16	Хүний нөөцийн талаарх мэдээлэл			
17	Холбоо барих хаяг			
18	Зөвшөөрлийн материал хүлээж авах хураамж төлсөн баримт			

Жич: Хүснэгт дэх “Тайлбар” хэсэгт ирүүлэхийг шаардсан баримт бичгийн бүрдүүлбэрийг хэрхэн хангаж байгаа талаар болон холбогдох материал, дүрэм, журам, гэрээний заалтыг тодорхой заана уу.